“ЛЭНДМН ББСБ **ХК** ”

**Хараат бус Аудиторын тайлан**

**2024 оны 12 дугаар сарын 31-ний өдөр**

**Нэгтгэсэн санхүүгийн тайлан**

**“ЛЭНДМН ББСБ” ХК**

**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГУУД**

---

| **АГУУЛГА** | **ХУУДАС** |
|---|---|
| КОМПАНИЙН МЭДЭЭЛЭЛ | 1 |
| ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГЫН МЭДЭГДЭЛ | 2 |
| ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ | 3-5 |
| АШИГ АЛДАГДАЛ БА БУСАД ДЭЛГЭРЭНГҮЙ ОРЛОГЫН ТАЙЛАН | 6 |
| САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН | 7 |
| ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН | 8 |
| МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН | 9 |
| САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД | 10-30 |

SHONKHOR 01 consulting & audit

**КОМПАНИЙН МЭДЭЭЛЭЛ**

| | |
|---|---|
| ТУЗ-ЫН ДАРГА | О.БОЛДБААТАР |
| ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ | Ц.УУГАНБАЯР |
| ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮД | Б.ХОС-ЭРДЭНЭ<br>MADONO KATSUHIKO<br>Ц.УУГАНБАЯР<br>Ц.ОДМАА<br>С.ЭНХ-АМГАЛАН |
| ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХАРААТ БУС ГИШҮҮД | С.БОРГИЛ<br>Ж.ЖАРГАЛСАЙХАН<br>С.НЭРГҮЙ |
| АЛБАН ХАЯГ | МОНГОЛ УЛС, УЛААНБААТАР ХОТ ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРЭГ 3-Р ХОРОО ЖУУЛЧНЫ ГУДАМЖ 34, СУВД ТӨВ |
| ХАРИЛЦАГЧ БАНК | ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК, ГОЛОМТ БАНК, ТӨРИЙН БАНК, ХАС БАНК, ХААН БАНК, КАПИТРОН БАНК, АРИГ БАНК, М БАНК |
| АУДИТОР | "ШОНХОР ҮНЭЛГЭЭ АУДИТ" ХХК |

SHONKHOR 01
estimate & audit

**“ШОНХОР ҮНЭЛГЭЭ АУДИТ” ХХК**

**РАССЕЛ БЕДФОРД ИНТЕРНЭШНЛ**
олон улсын сүлжээний гишүүн

**“ЛэндМН ББСБ” ХК-ийн**
**Хувьцаа эзэмшигчдэд**

2025.02.06 № 25/10

танай ______________ -ны № ________________-т

АУДИТОРЫН ТАЙЛАН

**Дүгнэлт**

Бид **“ЛэндМН ББСБ” ХК** -ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгон бэлтгэсэн Нэгтгэсэн санхүүгийн байдал, үйл ажиллагааны үр дүнгийн, өмчийн өөрчлөлтийн, мөнгөн гүйлгээний холбогдох тайлан, тодруулгад аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр **“ЛэндМН ББСБ” ХК** -ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх Нэгтгэсэн санхүүгийн байдал, үйл ажиллагааны үр дүн, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээг бүхий л материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлсэн байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Бид аудитаа Аудитын Олон Улсын Стандарт (АОУС)-ын дагуу хийж гүйцэтгэсэн болно. Энэ стандартын дагуу бидний хүлээх үүрэг хариуцлагыг энэхүү дүгнэлтийн санхүүгийн тайлангийн аудитад аудиторын хүлээх үүрэг хариуцлага хэсэгт харуулсан. Бид санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой ёс зүйн шаардлагуудын дагуу үйлчлүүлэгчээс хараат бус байх, эдгээр шаардлагуудын дагуух ёс зүйн бусад үүрэг хариуцлагуудыг мөрдөж ажилласан.

Аудитын ажилд санхүүгийн тайлангийн дүн болон тодруулгуудын талаар аудитын нотолгоо олж авах горимуудыг гүйцэтгэх ажил багтана. Аудитаар санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд, тэдгээрийн нэмэлт тодруулгыг нотлох нотолгоог түүвэр шалгалтын арга ашиглан магадлав.

Бидний олж авсан аудитын нотолгоо нь бидний гаргасан дүгнэлтэнд хангалттай, зохистой үндэслэл болж чадсан гэдэгт бид итгэлтэй байна.

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
1 хороо, Нарны зам-62, ЮНЕСКО-гийн гудамж,
Юнион билдинг Б блок, 14 давхарт, 1403 тоот

Утасны дугаар: +(976)-88880963, 80110088, 99005577
И-мэйл: shonkhormn@gmail.com
audit.rusbd@gmail.com

**Удирдлага ба Засаглах удирдлагын санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага нь санхүүгийн тайлангаа СТОУС-ын дагуу бэлтгэх ба үнэн зөв толилуулах нь удирдлагын үүрэг хариуцлага байдаг. Энэхүү хариуцлагад нягтлан бодох бүртгэлийн зохистой бодлогуудыг сонгон авч хэрэглэх, санхүүгийн тайланг нягтлан бодох бүртгэлийн тооцооллын алдаа, санаатай зальт үйлдлээс үүсэлтэй материаллаг буруу илэрхийлэлгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэх, толилуулахын тулд дотоод хяналтыг бий болгох, хэрэгжүүлэх, тогтмол хэрэглэх үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Банкны удирдлага нь санхүүгийн тайлангуудыг бэлтгэхдээ банкны үйл ажиллагааг тасралтгүй явуулах чадварыг үнэлэх, тасралтгүй байх зарчимтай холбоотой асуудлуудыг тодруулах, үйл ажиллагааг зогсоох эсвэл татан буулгахаар төлөвлөсөн эсвэл эдгээрээс өөр бодит сонголт байхгүйгээс бусад тохиолдолд санхүүгийн тайлангуудыг гаргахдаа тасралтгүй байх суурийг хэрэглэх үүрэгтэй.

Засаглал хариуцсан этгээдүүд нь Компанийн санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэгтэй.

**Санхүүгийн тайлангийн аудитад аудиторын хүлээх үүрэг, хариуцлага**

Санхүүгийн тайлан нь залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу тайлагналуудаас бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаа олж авах, дүгнэлт бүхий аудиторын тайлан гаргах нь бидний зорилго юм.

Зохистой баталгаажуулалт гэдэг нь өндөр түвшний баталгаажуулалт боловч АОУС-ын дагуу хийгдсэн аудит нь оршин байгаа материаллаг буруу тайлагналуудыг байнга илрүүлнэ гэсэн баталгаа биш юм. Буруу тайлагналууд нь залилан эсвэл алдаанаас үүсч болох ба хэрэв тэдгээр нь дангаараа эсвэл нийтдээ санхүүгийн тайланд үндэслэн гаргасан хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллагт тооцогдоно.

АОУС-ын дагуу хийх аудитын үед бид мэргэжлийн үнэлэмж, мэргэжлийн үл итгэх зарчмыг баримтлан ажилладаг. Бид мөн:

- Залилан эсвэл алдааны улмаас үүсч болох санхүүгийн тайлангийн материаллаг буруу тайлагналуудын эрсдэлүүдийг таних, үнэлэх, тэдгээр эрсдэлд тохирох аудитын горимуудыг боловсруулах, гүйцэтгэх, өөрсдийн дүгнэлтэнд үндэслэл болохуйц хангалттай, зохистой аудитын нотолгоог олж авах.
- Залилан нь хуйвалдах, бичиг баримт хуурамчаар үйлдэх, санаатайгаар орхигдуулах, буруу мэдэгдэл хийх, дотоод хяналтыг зөрчих зэрэг үйлдлүүдтэй холбоотой байж болох тул залилангаас үүдэн гарсан материаллаг буруу тайлагналыг илрүүлэхгүй байх эрсдэл нь алдаанаас үүдэн гарсан буруу тайлагналыг ирүүлэхгүй байх эрсдэлээс өндөр байдаг.

- Хэрэглэсэн нягтлан бодох бүртгэлийн бодлогууд нь зохистой эсэх, удирдлагын зүгээс нягтлан бодох бүртгэлийн ойролцоолсон тооцооллууд, тэдгээрт холбогдох тодруулгууд нь үндэслэлтэй эсэхийг үнэлэх.
- Нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг удирдлага зохистой хэрэглэсэн эсэх, олж авсан аудитын нотолгоонд үндэслэн Компанийн үйл ажиллагаагаа тасралтгүй явуулах чадамжид мэдэгдэхүйц эргэлзээ үүсгэж болох үйл явдал эсвэл нөхцөл байдалтай холбоотой материаллаг тодорхой бус байдал байгаа эсэхийг дүгнэх.
- Хэрэв материаллаг тодорхой бус байдал байна гэж дүгнэвэл, бид аудиторын тайландаа санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгыг хийж өгөх эсвэл ийм тодруулга хангалтгүй бол дүгнэлтээ өөрчлөх шаардлагатай болдог. Аудиторын тайлан гарах өдөр хүртэл олж авсан аудитын нотолгоонд үндэслэн бид дүгнэлтээ гаргадаг. Гэхдээ ирээдүйн үйл явдал эсвэл нөхцөл байдал Компанийн тасралтгүй байх зарчмыг алдагдуулж болно.
- Санхүүгийн тайлангууд (үүнд тодруулгууд багтана)-ын ерөнхий толилуулга, бүтэц, агуулгыг үнэлэх мөн санхүүгийн тайлангууд нь зөв толилуулгын шаардлагыг хангахуйц байдлаар холбогдох ажил гүйлгээ, үйл явдлуудыг илэрхийлсэн эсэхийг үнэлэх.

(Энэхүү дүгнэлт нь хавсралтын хамт хүчин төгөлдөр болно.)

ЗАХИРАЛ Д.ШИЙРЭВ

BEDFORD
УЛААНБААТАР ХОТ
ШОНХОР ҮНЭЛГЭЭ АУДИТ ХХК
MEMBER

## НЭГТГЭСЭН АУДИТЛАГДСАН ОРЛОГЫН ТАЙЛАН

2024 оны 12 сарын 31 -ний өдрөөр дуусгавар болсон тайлант үе

**"ЛэндМН ББСБ" ХК** *|мян.төг|*

| Үзүүлэлт | 2024.12.31 | 2023.12.31 |
|---|---|---|
| Борлуулалтын орлого | 88,801,668 | 47,982,386 |
| Борлуулсан бүтээгдэхүүний өртөг | - | - |
| **Нийт ашиг ( алдагдал)** | **88,801,668** | **47,982,386** |
| Түрээсийн орлого | - | - |
| Хүүний орлого | 388,368 | 29,685 |
| Бусад орлого | 271,656 | 149,139 |
| Борлуулалт, маркетингийн зардал | 425,855 | 482,738 |
| Ерөнхий ба удирдлагын зардал | 12,379,511 | 9,920,786 |
| Санхүүгийн зардал | 22,181,544 | 9,434,248 |
| Бусад зардал | 8,201,425 | 3,095,828 |
| Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз) | -146,098 | 143,113 |
| **Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)** | **46,127,259** | **25,370,723** |
| Орлогын татварын зардал | 10,013,611 | 5,574,907 |
| **Татварын дараахь ашиг (алдагдал)** | **36,113,649** | **19,795,816** |
| **Тайлант үеийн цэвэр ашиг ( алдагдал)** | **36,113,649** | **19,795,816** |
| **Толгой компанийн хувьцаа эзэмшигчид** | **36,113,649** | **19,795,816** |

| | **төг** | **төг** |
|---|---|---|
| Нэгж хувьцаанд ногдох ашиг | | |
| Компанийн хувьцаа эзэмшигчдийн нэгж хувьцаанд ногдох үндсэн болон шингэрсэн ашиг | 48.85 | 26.78 |

**НЭГТГЭСЭН АУДИТЛАГДСАН САНХҮҮ БАЙДЛЫН ТАЙЛАН**

2024 оны 12 сарын 31 -ний өдрөөр дуусгавар болсон тайлант үе

**"ЛэндМН ББСБ" ХК** *|мян.төг|*

| Балансын зүйл | 2024.12.31 | 2023.12.31 |
|---|---|---|
| **Хөрөнгө** | | |
| **Эргэлтийн хөрөнгө** | | |
| Мөнгөн хөрөнгө | 12,706,074 | 7,885,967 |
| Дансны авлага | 717,913 | 426,590 |
| Бусад авлага | 1,094,548 | - |
| Зээл /цэврээр/ | 231,727,567 | 123,462,373 |
| Бараа материал | 4,116 | 15,613 |
| Урьдчилж төлсөн зардал/тооцоо | 392,103 | 55,975 |
| Өмчлөх бусад хөдлөх хөрөнгө | 11,000 | 15,080 |
| **Эргэлтийн хөрөнгийн дүн** | **246,653,321** | **131,861,598** |
| **Эргэлтийн бус хөрөнгө** | | |
| Үндсэн хөрөнгө | 4,942,878 | 1,251,811 |
| Биет бус хөрөнгө | 754,673 | 355,542 |
| **Эргэлтийн бус хөрөнгийн дүн** | **5,697,551** | **1,607,353** |
| **Нийт хөрөнгийн дүн** | **252,350,872** | **133,468,951** |
| **Өр төлбөр** | | |
| **Богино хугацаат өр төлбөр** | | |
| Дансны өглөг | 5,109,254 | 3,876,599 |
| Цалингийн өглөг | - | 309,972 |
| Татварын өглөг | 4,279,392 | 4,080,482 |
| НДШ-ийн өглөг | - | 38,505 |
| Богино хугацаат зээл | 75,329,520 | 8,124,018 |
| Хүүний өглөг | - | 1,474,622 |
| Бусад богино хугацаат өр төлбөр | - | 227,644 |
| Итгэлцлийн үйлчилгээний өглөг | 62,594,178 | 35,661,746 |
| **Богино хугацаат өр төлбөрийн дүн** | **147,312,344** | **53,793,589** |
| Урт хугацаат өр төлбөр | | |
| Урт хугацаат өр төлбөр | 2,945,392 | 20,350,164 |
| Нөөц /Болзошгүй өр төлбөр / | 113,351 | |
| Хойшлогдсон татварын өр төлбөр | 19,776 | |
| Бусад урт хугацаат өр төлбөр | 29,028,833 | 16,593,258 |
| **Урт хугацаат өр төлбөрийн дүн** | **32,107,353** | **36,943,422** |
| **Нийт өр төлбөрийн дүн** | **179,419,697** | **90,737,012** |
| **Өмч** | | |
| Хувьцаат | 8,000,000 | 8,000,000 |
| Халаасны хувьцаа | (2,337,547) | (2,337,547) |
| Нэмж төлөгдсөн капитал | 2,756,859 | 2,756,859 |
| Эздийн өмчийн бусад хэсэг | 57,348 | 57,348 |
| Хуримтлагдсан ашиг | 64,454,515 | 34,255,279 |
| **Нийт өмчийн дүн** | **72,931,175** | **42,731,939** |
| **Нийт өр төлбөр ба өмчийн дүн** | **252,350,872** | **133,468,951** |

## НЭГТГЭСЭН АУДИТЛАГДСАН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

2024 оны 12 сарын 31 -ний өдрөөр дуусгавар болсон тайлант үе

**"ЛэндМН ББСБ" ХК** *//мян.төг//*

| ҮЗҮҮЛЭЛТ | Хувь нийлүүлсэн хөрөнгө | Нэмж төлөгдсөн капитал | Халаасны хувьцаа | Бусад нөөц | Хуримтлагдсан ашиг | Нийт Эздийн өмч |
|---|---|---|---|---|---|---|
| **2022 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар** | **8,000,000** | **2,756,859** | **(2,337,547)** | **57,348** | **34,255,279** | **42,731,939** |
| Тайлант жилийн цэвэр ашиг болон тайлант жилийн нийт дэлгэрэнгүй орлого | - | - | - | - | - | - |
| Ногдол ашиг | - | - | - | - | - | - |
| **2023 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар** | **8,000,000** | **2,756,859** | **(2,337,547)** | **57,348** | **34,255,279** | **42,731,939** |
| Тайлант жилийн цэвэр ашиг болон тайлант жилийн нийт дэлгэрэнгүй орлого | - | - | - | - | 36,113,649 | 36,113,649 |
| Ногдол ашиг | - | - | - | - | -5,914,413 | -5,914,413 |
| **2024 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар** | **8,000,000** | **2,756,859** | **(2,337,547)** | **57,348** | **64,454,515** | **72,931,175** |

RUSSELL BEDFORD INTERNATIONAL MEMBER
ШОНХОР ҮНЭЛГЭЭ АУДИТ ХХК

**НЭГТГЭСЭН АУДИТЛАГДСАН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН**
2024 оны 12 сарын 31 -ний өдрөөр дуусгавар болсон тайлант үе

**"ЛэндМН ББСБ" ХК** *//мян.төг//*

| Үзүүлэлт | 2024.12.31 | 2023.12.31 |
|---|---|---|
| Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ | | |
| Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний | 976,922,326 | 31,815,095 |
| Бусад мөнгөн орлого | 21,979,252 | 675,155,764 |
| **Үндсэн үйл ажиллагааны мөнгөн орлого** | **998,901,578** | **706,970,859** |
| Ажиллагчдад төлсөн | 3,256,463 | 125,861 |
| Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн | 1,564 | 630,976 |
| Ашиглалтын зардалд төлсөн | 14,271 | 11,692 |
| Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн | - | 303,456 |
| Хүүний төлбөрт төлсөн | - | 3,596,666 |
| Татварын байгууллагад төлсөн | 12,350,615 | 3,683,876 |
| Бусад мөнгөн зарлага | 1,047,311,217 | 711,715,140 |
| **Үндсэн үйл ажиллагааны мөнгөн зарлага** | **1,062,934,131** | **720,067,668** |
| **Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн** | **(64,032,553)** | **(13,096,809)** |
| Хүлээн авсан хүүгийн орлого | 349,588 | 26,106 |
| Хүлээн авсан ногдол ашиг | - | - |
| **Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн орлого** | **349,588** | **26,106** |
| Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн | 1,388,430 | - |
| Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн | 1,094,548 | - |
| **Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн зарлага** | **2,482,978** | - |
| **Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн** | **(2,133,391)** | **26,106** |
| Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ | - | - |
| Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан | 258,048,492 | 9,000,000 |
| Бусад мөнгөн орлого | - | 35,542,790 |
| **Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн** | **258,048,492** | **44,542,790** |
| Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн | 181,305,806 | 27,579,047 |
| Төлсөн ногдол ашиг | 5,756,635 | 1,224,653 |
| **Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн** | **187,062,442** | **28,803,700** |
| **Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн** | **70,986,050** | **15,739,091** |
| **Бүх цэвэр мөнгөн гүйлгээ** | **4,820,106** | **2,668,388** |
| **Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | **7,885,967** | **5,217,580** |
| **Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | **12,706,074** | **7,885,967** |

УЛААНБААТАР ХОТ
RUSSELL INTERNATIONAL
ШИ ... НЭГТГЭЗ АУДИТ ХХК
MEMBER

## 1. КОМПАНИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

**"ЛЭНДМН ББСБ" ХК** (цаашид "Компани" гэх) нь Монголын Хөрөнгийн Биржид (цаашид "МХБ" гэх) бүртгэлтэй, тус улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг, хувь нийлүүлсэн хувьцаат компани. Компани нь 2018 оны 3 дугаар сарын 14-ний өдөр МХБ дээр бүртгэлтэй болсноор нээлттэй хувьцаат компани болсон. Компани нь Санхүүгийн Зохицуулах Хорооноос (цаашид "СЗХ" гэх) 2015 оны 6 дугаар сарын 24-ний өдөр олгосон 1/493 тоот банк бус санхүүгийн байгууллагын тусгай зөвшөөрлийн дагуу зээлийн үйл ажиллагааг явуулж байна. Түүнчлэн Компани нь СЗХ-оос 2019 оны 3 дугаар сарын 20-ны өдөр олгогдсонтоот дугаартай Итгэлцлийн болон Факторингийн үйлчилгээ, 2019 оны 5 дугаар сарын 23-ны өдөр олгогдсон 128 тоот дугаартай Гадаад валютын арилжаа эрхлэх үйл ажиллагааны тусгай зөвшөөрлүүдийн дагуу үйл ажиллагаагаа явуулж байна

**Компанийн албан ёсны хаяг нь:** Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 3-р хороо, Жуулчны гудамж 34, Сувд төв

**Компанийн үндсэн үйл ажиллагааны чиглэл нь**: Компани нь зэргэлдээ охин компани болох Монгол Улсад үүсгэн байгуулагдсан Анд Системс Тех ХХК ("АНД Системс Тех") -ийн хөгжүүлэн гаргасан ЛэндМН технологийг ашиглан зээлийн үйлчилгээ огт/хангалттай хэмжээнд авч чаддаггүй хүмүүст гар утсанд суурилсан санхүүгийн үйлчилгээ буюу 24/7 цахим зээлийн үйлчилгээг үзүүлдэг. ЛэндМН технологи нь Анд Системс Тех-ийн хөгжүүлэн гаргасан "финтек" шийдэл бүхий технологи бөгөөд технологийн лицензийг Анд Системс Тех эзэмшдэг. 2018 онд Компани нь ЛэндМН технологиор дамжуулан төрөл бүрийн төлбөр тооцоо, санхүүгийн гүйлгээ хийх "Лэнд Хэтэвч" шинэ бүтээгдэхүүнийг нэвтрүүлэн үйл ажиллагааны цар хүрээгээ өргөжүүлсэн

**Компанийн эцсийн толгой компани** нь Сингапур Улсад бүртгэлтэй, финтек компани болох Анд Глобал Пти.Лтд.

Компанийн санхүүгийн тайлан дахь дүнгүүдийг тодруулгад өөрөөр зааснаас бусад тохиолдолд мянганы орноор, Монгол төгрөг ("төг")-өөр тайлагнасан.

## 2. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГУУД

### 2.1 Тайлан бэлтгэх үндэслэл

Компанийн санхүүгийн тайланг түүхэн өртгийн зарчмаар бэлтгэсэн ба санхүүгийн тайлан дахь дүнгүүдийг тодруулгад өөрөөр зааснаас бусад тохиолдолд мянганы орноор, Монгол төгрөгөөр тайлагнасан.

**Нийцтэй байдлын мэдэгдэл**

Компанийн санхүүгийн тайлангууд нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөл (НББОУСЗХ)-өөс баталж гаргасан санхүүгийн тайлагналын олон улсын стандартууд (СТОУС)-ын дагуу бэлтгэгдсэн болно.

## 2. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГУУД (ҮРГЭЛЖЛЭЛ)

### 2.1 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын товчоо

#### a. Эргэлтийн болон эргэлтийн бус ангилал

Компани хөрөнгө болон өр төлбөрүүдийг санхүүгийн байдлын тайланд эргэлтийн болон эргэлтийн бус ангиллын дагуу толилуулна. Дараах тохиолдолд хөрөнгө эргэлтийн хөрөнгө болно:

- Хэвийн үйл ажиллагааны явцад хэрэгжих болон борлуулах хандлагатай эсвэл хэрэглэхээр хүлээгдэж байгаа
- Худалдах үндсэн зорилгоор эзэмшиж байгаа
- Тайлант хугацаанаас хойш 12 сарын дотор хэрэгжихээр хүлээгдэж байгаа эсвэл
- Тайлант хугацаанаас хойш хамгийн багадаа 12 сарын дотор солилцох эсвэл өр төлбөр барагдуулахыг хязгаарлаагүй бэлэн мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө

Бусад бүх хөрөнгө нь эргэлтийн бус хөрөнгө болно.
Өр төлбөр нь дараах тохиолдлуудад богино хугацаат өр төлбөр болно:

- Хэвийн үйл ажиллагааны явцад төлөгдөхөөр хүлээгдэж буй
- Худалдах үндсэн зорилгоор эзэмшиж байгаа
- Тайлант хугацаанаас хойш 12 сарын дотор төлөх хугацаатай, эсвэл
- Тайлант хугацаанаас хойш хамгийн багадаа 12 сар өр төлбөр барагдуулалтыг хойшлуулах нөхцөлгүй

Компани бусад бүх өр төлбөрүүдийг эргэлтийн бус гэж ангилдаг.

SHONKHOR estimate & audit

## 2. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГУУД (ҮРГЭЛЖЛЭЛ)

### 2.1 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын товчоо (үргэлжлэл)

**б. Гадаад валютын хөрвүүлэлт**

Компанийн санхүүгийн тайланг Компанийн үйл ажиллагааны мөнгөн тэмдэгт болох Монгол төгрөгөөр илэрхийлнэ. Гадаад валютын гүйлгээг анх бүртгэхдээ гүйлгээг хүлээн зөвшөөрөх шаардлага хангасан өдрийн ханшаар мөнгөн нэгжрүү хөрвүүлж бүртгэнэ. Гадаад валютаар бүртгэгдсэн мөнгөн хөрөнгө, төлбөрүүдийг санхүүгийн байдлын тайлангийн өдрийн ханшаар дахин хөрвүүлдэг. Бүх зөрүүг орлого, зардлын дансанд бүртгэнэ.

Түүхэн өртгөөр хэмжигдэх мөнгөн бус зүйлүүдийг тэдгээрийн анхны гүйлгээ хийгдсэн өдрийн ханшаар хөрвүүлнэ. Бодит үнэ цэнэ нь гадаад валютаар хэмжигдэх мөнгөн бус зүйлүүдийг бодит үнэ цэнэ тодорхойлогдсон өдрийн ханшаар хөрвүүлнэ. Бодит үнэ цэнээр хэмжигдэх, мөнгөн зүйлсийн хөрвүүлгээс үүссэн олз, гарзыг бодит үнэ цэнийн өөрчлөлтийн олз, гарзыг хүлээн зөвшөөрөхтэй адилаар хүлээн зөвшөөрнө (өөрөөр хэлбэл бодит үнэ цэнийн зөрүү нь бусад дэлгэрэнгүй орлого, олз гарзын тайланд хүлээн зөвшөөрөгдсөн зүйлийн ханшийн зөрүүнээс үүссэн олз, гарзыг мөн адил бусад дэлгэрэнгүй орлого, олз гарзын тайланд бүртгэнэ).

**в. Орлого болон зардлын хүлээн зөвшөөрөлт**

Хүүний орлого эсвэл хүүний зардлыг чанаргүй төлөвт орсон хэрэглүүрээс бусад санхүүгийн хэрэглүүрийн хувьд үр ашигт хүүний аргыг ашиглан аккруэл суурьтай бүртгэнэ. Энэ аргын дагуу гэрээний талуудын хооронд төлөгдсөн эсвэл хүлээн авсан бүх хураамж, гүйлгээний зардал болон бүх урамшуулал, хөнгөлөлтийг үр ашигт хүүнд оруулан тооцож, цаг хугацааны хувьд хойшлуулан хүүний орлого эсвэл зардалд бүртгэдэг. Үр ашигт хүүний бүрэлдэхүүн хэсэг болох хураамжид санхүүгийн хөрөнгийг худалдан авах эсвэл санхүүгийн өр төлбөрийг үүсгэхтэй холбоотойгоор нэмэгдэн гарсан, Компанийн төлсөн эсвэл хүлээн авсан хураамжууд багтдаг ба жишээлбэл үүнд төлбөрийн чадварыг үнэлэх, санхүүгийн хэрэглүүрийн нөхцөл тохиролцох, холбогдох баримт бичиг боловсруулахтай холбоотойгоор нэмэгдэн гарсан аливаа хураамжууд орно. Зээлийн олголт бүрд ногдуулж буй ЛэндМН хураамжийн орлого нь хүүний орлого гэж нэрлэгдэхгүй боловч үр ашигт хүүний нэг хэсэг юм.

SHONKHOR 01
valuation & audit

## 2. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГУУД (ҮРГЭЛЖЛЭЛ)

### 2.1 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын товчоо (үргэлжлэл)

#### в. Орлого болон зардлын хүлээн зөвшөөрөлт (үргэлжлэл)

Санхүүгийн хөрөнгө нь чанаргүй төлөвт орж, ЗҮЦХА-ын загварын 3-р шатлалын хөрөнгөөр ангилагдсан тохиолдолд Компани нь хүүний орлогыг санхүүгийн хөрөнгийн цэвэр хорогдуулсан өртгөөс үр ашигт хүүний түвшинг ашиглан тооцдог. Хэрэв санхүүгийн хөрөнгийн чанар сайжирч, чанаргүй төлвөөс гарсан тохиолдолд хүүний орлогыг эргээд нийт дансны үнээс тооцно. Компани нь худалдаж авахад эсвэл анх олгоход үнэ цэнийн бууралттай байсан (ХАОҮЦБ) санхүүгийн хөрөнгийн хүүний орлогыг хөрөнгийн хорогдуулсан өртгөөс зээлийн тохируулсан үр ашигт хүүний түвшинг ашиглан тооцно. Зээлийн тохируулсан үр ашигт хүү гэдэг нь анхлан хүлээн зөвшөөрөлтийн өдрөөр тооцоолсон ирээдүйн мөнгөн урсгалыг (зээлийн алдагдлыг оруулсан) ХАОҮЦБ хөрөнгийн хорогдуулсан өртөг рүү дискаунтлах хүүний хувь юм.

Бусад бүх шимтгэл, хураамж болон бусад орлого, зардлын зүйлүүдийг нийтлэг байдлаар нь аккруэл сууриар тухайн ажил гүйлгээний гүйцэтгэлтэй уялдуулан хүлээн зөвшөөрөх бөгөөд гүйцэтгэлийг нийт үзүүлэх үйлчилгээнд эзлэх бодитоор үзүүлсэн үйлчилгээний хэсэгт үндэслэн тооцдог.

#### г. Ажиллагсдын зардал болон холбогдох шимтгэлүүд

Цалин хөлс болон цалинтай холбоотой бусад зардлуудыг Компанийн ажиллагсад холбогдох ажил үйлчилгээ үзүүлсэн жилд зардлаар хүлээн зөвшөөрдөг. Цалинтай ээлжийн амралт гэх мэт богино хугацааны, хуримтлагдах цалинтай чөлөөг ирээдүйд цалинтай чөлөө авах эрхээ нэмэгдүүлэн, ажил үйлчилгээ үзүүлсэн тайлант хугацаанд хүлээн зөвшөөрнө.

#### д. Татвар

*Тайлант хугацааны орлогын албан татвар*

Тайлант жилийн болон өмнөх хугацааны албан татварын хөрөнгө ба өр төлбөрийг татварын байгууллагаас буцаан авахаар хүлээж байгаа эсвэл татварын байгууллагад төлөх дүнгээр хэмжинэ. Энэ дүнг тооцоолоход хэрэглэсэн татварын хувь хэмжээ, татварын хуулиуд нь санхүүгийн байдлын тайлангийн өдрийн байдлаар хүчин төгөлдөр үйлчилж байсан болно.

Эдгээр зүйлд холбоотой тайлант жилийн орлогын албан татварыг орлого үр дүнгийн тайланд биш шууд өөрийн хөрөнгөд хүлээн зөвшөөрнө. Удирдлага НББ-ийг хэрхэн хөтлөхийг холбогдох татварын хууль, журмуудад тодорхой зааж өгөөгүй, нэмэлт тайлбар тодруулга шаардлагатай тийм шинэ нөхцөл байдал үүссэн эсэхийг тодруулахын тулд тодорхой хугацаа тутамд татварын тайлангаа хянаж үздэг ба шаардлагатай бол сан байгуулдаг.

SHONKHOR estimate & audit

## 2. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГУУД (ҮРГЭЛЖЛЭЛ)

### 2.1 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын товчоо (үргэлжлэл)

**д. Татвар(үргэлжлэл)**

*Хойшлогдсон албан татвар*

Компанийн санхүүгийн байдлын тайлангийн өдрийн байдлаарх хөрөнгө, өр төлбөрийн татвар ногдох дүн ба тэдгээрийн санхүүгийн тайлан дээрх бүртгэлийн хооронд гарах түр зөрүүнд "Тайлан тэнцлийн арга"-ыг ашиглан хойшлогдсон албан татварыг хүлээн зөвшөөрнө.

Хойшлогдсон албан татварын өр төлбөрийг дор дурдсанаас бусад бүх түр зөрүүнд хүлээн зөвшөөрнө. Үүнд:

*Хойшлогдсон албан татвар(үргэлжлэл)*

- Хойшлогдсон албан татварын өр төлбөр нь гүүдвилийг анх хүлээнзөвшөөрөх үед эсвэл бизнесийн нэгдлийн бус хөрөнгө, өр төлбөрийн гүйлгээнээс үүссэн, уг гүйлгээ нь НББ-ийн ашиг (алдагдал), татвар ногдох ашиг (алдагдал) - ийн аль алинд нөлөө үзүүлэхгүй байгаа үед,
- Түр зөрүү нь охин болон холбоотой компаниудад оруулсан хөрөнгөоруулалт ба хамтарсан компани дахь ашиг сонирхол зэрэгтэй холбоотойгоор үүссэн, түр зөрүүг хэзээ арилгахыг толгой компани, хөрөнгө оруулагч эсвэл хамтрагч тал хянаж байгаа, түр зөрүү нь ойрын хугацаанд арилахгүй байх магадлалтай байгаа үед

Дор дурдсанаас бусад тохиолдолд хойшлогдсон орлогын албан татварын хөрөнгийг татвар ногдох орлогоос хасагдах бүх түр зөрүүнүүд, ирээдүйд шилжүүлэн тооцох, ашиглаагүй татварын бүх хөнгөлөлт ба алдагдлуудад (эдгээр түр зөрүү, хөнгөлөлт, алдагдлуудыг хасаж болох татвар ногдох орлогын ирээдүйд орж ирэх нь тодорхой болсон үед) хүлээн зөвшөөрнө. Үүнд:

- Татвар ногдох орлогоос хасагдах түр зөрүүтэй холбоотой хойшлогдсон албан татварын хөрөнгө нь бизнесийн нэгдлийн бус хөрөнгө, өр төлбөрийн гүйлгээг анх хүлээн зөвшөөрөх үед үүссэн ба гүйлгээ гарах үед, НББ-ийн болоод татварын ашиг (алдагдал) - ийн аль алинд нөлөө үзүүлэхгүй байгаа үед;

- Татвар ногдох орлогоос хасагдах түр зөрүү нь охин болон холбоотой компаниудад оруулсан хөрөнгө оруулалт ба хамтарсан компани дахь ашиг сонирхолтой холбоотойгоор үүссэн бол хойшлогдсон албан татварын хөрөнгийг, түр зөрүү нь ойрын хугацаанд арилах магадлалтай, түр зөрүүг хасаж болох татвар ногдох орлого орж ирэх нь тодорхой болсон үед зөвхөн хүлээн зөвшөөрнө.

SHONKHOR estimate & audit 01

## 2. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГУУД (ҮРГЭЛЖЛЭЛ)

### 2.1 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын товчоо (үргэлжлэл)

#### д. Татвар(үргэлжлэл)

Хойшлогдсон татварын хөрөнгийн бүртгэлийн дүнг тайлант хугацаа бүрийн эцэст хянаж үзэх ба хойшлогдсон татварын хөрөнгийг хэсэгчлэн эсвэл бүхлээр нь нөхөн олж авахад хүрэлцэхүйц хэмжээний татвар ногдох орлого цаашид орж ирэх нь тодорхойгүй болсон үед харгалзах хэмжээгээр хөрөнгийн дүнг бууруулна.

Хүлээн зөвшөөрөөгүй хойшлогдсон татварын хөрөнгийг тайлант хугацаа бүрийн эцэст дахин үнэлж үзэх ба хойшлогдсон татварын хөрөнгийг нөхөн олж авахад хүрэлцэхүйц хэмжээний татвар ногдох орлого цаашид орж ирэх нь тодорхой болсон үед харгалзах хэмжээгээр хойшлогдсон татварын хөрөнгийг хүлээн зөвшөөрнө.

Хойшлогдсон татварын хөрөнгө, өр төлбөрийн тайлант хугацааны эцсийн өдрийн байдлаар хүчин төгөлдөр үйлчилж буй татварын хувь хэмжээнүүд дээр үндэслэн хөрөнгийг борлуулах, өр төлбөрийг барагдуулах тайлант хугацаанд хэрэглэгдэхээр хүлээгдэж буй татварын хэмжээгээр хойшлогдсон татварыг тооцно.

*Хойшлогдсон албан татвар(үргэлжлэл)*
Хэрэв өнөөгийн татварын хөрөнгийг татварын өр төлбөрт суутгуулах хууль ёсны эрхтэй бөгөөд хойшлогдсон татварууд нь нэг татвар төлөгч аж ахуйн нэгж ба нэг татварын байгууллагатай холбоотой байгаа бол хойшлогдсон албан татварын хөрөнгө ба өр төлбөрийг хооронд нь цэвэршүүлж болно.

*Нэмэгдсэн өртгийн албан татвар*
Орлого, зардал болон хөрөнгүүд нь доорхоос бусад тохиолдолд Нэмэгдсэн Өртгийн Албан Татвар (НӨАТ)-гүй цэвэр дүнгээр хүлээн зөвшөөрөгддөг:

- Хөрөнгө эсвэл үйлчилгээг худалдан авахад төлсөн НӨАТ-ыг татварын байгууллагаас буцаан авах боломжгүй үед уг НӨАТ-ыг хөрөнгө худалдан авалтын өртгийн нэг хэсгээр эсвэл зардлын нэг хэсгээр (аль тохиромжтойгоор) хүлээн зөвшөөрнө.
- НӨАТ-ын дүн орсон дүнгээр илэрхийлэгдэх авлага ба өглөг.

Татварын байгууллагаас авах эсвэл татварын байгууллагад өгөх өглөгийн цэвэр дүнг санхүүгийн байдлын тайланд авлага эсвэл өглөгийн нэг хэсэг болгон толилуулна.

## 2. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГУУД (ҮРГЭЛЖЛЭЛ)

### 2.1 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын товчоо (үргэлжлэл)

**е. Бэлэн мөнгө болон банкин дахь данс**

Бэлэн мөнгө болон банкин дахь дансанд банкинд байршуулсан мөнгө орно.

Мөнгөн гүйлгээний тайлангийн зорилгоор, дээр тодорхойлсноор бэлэн мөнгө болон банкин дахь харилцах, хадгаламж дахь бэлэн мөнгө болон богино хугацаатай хадгаламжийг банкны овердрафтын үлдэгдлийг багтаахгүйгээр оруулсан.

**ё. Санхүүгийн хөрөнгө**

*(i) Анх хүлээн зөвшөөрөх болон хэмжилт*

Харилцагчдад олгосон зээл болон урьдчилгаа, бусад авлагаас бусад санхүүгийн хөрөнгө болон өр төлбөрүүдийг анхлан хүлээн зөвшөөрөхдөө арилжаа хийсэн өдөр (Компани тухайн хэрэглүүрийн гэрээний нэг тал болсон өдөр) хүлээн зөвшөөрнө. Үүнд "хэвийн нөхцөлтэй арилжаа" буюу санхүүгийн хөрөнгө худалдан авах, худалдахад холбогдох хөрөнгийг зах зээлийн журам, хэлцлээр тогтоосон хугацаанд зайлшгүй шилжүүлэхийг шаарддаг арилжаа орно. Харилцагчдад олгосон зээл болон урьдчилгаа, бусад авлагыг харилцагчдын дансанд мөнгө шилжсэн үед хүлээн зөвшөөрнө.

Анхлан хүлээн зөвшөөрч буй санхүүгийн хэрэглүүрийн ангилал нь түдгээрийн гэрээний нөхцөл болон үг санхүүгийн хэрэглүүрийг зохицуулж буй бизнес загвараас хамаардаг. Санхүүгийн хэрэглүүрийг бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг алдагдалд бүртгэгдэх санхүүгийн хөрөнгө болон өр төлбөрөөс бусад тохиолдолд ажил гүйлгээний зардлыг бодит үнэ цэнээс хассан дүнгээр анхлан бүртгэнэ.

*(i) Дараах үеийн хэмжилт*

*Зээл ба авлага*
Зээл ба авлага нь идэвхтэй зах зээлд бүртгэлгүй, тогтмол эсвэл тодорхойлж болох төлбөр бүхий үүсмэл санхүүгийн хэрэглүүр биш санхүүгийн хөрөнгө юм. Анхны хэмжилтээс хойш санхүүгийн хөрөнгийг дараах үеүдэд үнэ цэнийн бууралтыг хассаны дараах үр ашигт хүүгийн арга (ҮАХА) ашиглан хорогдуулсан өртгөөр нь хэмжинэ. Хорогдуулсан өртгийг үр ашигт хүүний салшгүй хэсэг болох худалдан авалтын урамшуулал, хөнгөлөлт болон зардал, шимтгэлийг оролцуулан тооцдог. Үр ашигт хүүгийн хорогдуулалт нь дэлгэрэнгүй орлогын тайлангийн "Бусад орлого"-д багтана. Үнэ цэнийн бууралтаас үүссэн алдагдлыг дэлгэрэнгүй орлогын тайлангийн "Бусад зардал" хэсэгт хүлээн зөвшөөрнө.

SHONKHOR estimate & audit

## 2. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГУУД (ҮРГЭЛЖЛЭЛ)

### 2.1 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын товчоо (үргэлжлэл)

#### ё. Санхүүгийн хөрөнгө(үргэлжлэл)

(i) *Үл хүлээн зөвшөөрөлт*

Дараах тохиолдолд санхүүгийн хөрөнгийг (хэрэглэх боломжтой бол, санхүүгийн хөрөнгийн хэсгийг эсвэл хоорондоо төсөөтэй нэг бүлэг санхүүгийн хөрөнгүүдийн хэсгийг) үл хүлээн зөвшөөрнө. Үүнд:

- Тухайн хөрөнгөөс мөнгөн урсгал хүлээн авах эрх нь дууссан, эсвэл
- Компани нь тухайн хөрөнгөөс мөнгөн урсгал хүлээн авах эрхээ шилжүүлсэн эсвэл "дамжуулан өнгөрөөх" хэлцлийн дагуу хүлээн авсан мөнгөө нийт дүнгээр нь удаан хугацаагаар саатуулалгүйгээр гуравдагч талд төлөх үүрэг хүлээсэн, эсвэл (а)Компани нь хөрөнгийн бараг бүх эрсдэл ба өгөөжийг шилжүүлсэн, эсвэл(б)Компани нь тухайн хөрөнгөтэй холбоотой эрсдэл ба өгөөжийг шилжүүлээгүй боловч хөрөнгийн хяналтыг шилжүүлсэн.

Компани хөрөнгөөс мөнгө хүлээн авах эрхээ шилжүүлсэн эсвэл "дамжуулан өнгөрөөх" хэлцэл хийсэн боловч хөрөнгөтэй холбоотой ихэнх эрсдэл,өгөөж болон хяналтыг шилжүүлээгүй тохиолдолд хөрөнгийг Компанийн уг хөрөнгөнд үргэлжлүүлэн оролцсоор байх хэмжээгээр нь хүлээн зөвшөөрнө. Энэ тохиолдолд Компани холбогдох өр төлбөрийг мөн хүлээн зөвшөөрнө.

Шилжүүлсэн хөрөнгө ба холбогдох өр төлбөр Компанийн хадгалж үлдсэн эрх, үүргийг тусган харуулсан сууриар хэмжинэ. Энэхүү үргэлжилсэн оролцоо нь шилжүүлсэн хөрөнгийн баталгаа хэлбэртэй байвал оролцоог тус хөрөнгийн анхны бүртгэлийн дүн ба Компанийн төлөх шаардлагатай болох хамгийн их дүнгийн аль багаар хэмжинэ.

SHONKHOR estimate & audit 01

## 2. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГУУД (ҮРГЭЛЖЛЭЛ)

### 2.1 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын товчоо (үргэлжлэл)

#### ё. Санхүүгийн хөрөнгө (үргэлжлэл)

*(ii) Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралт*

Компани санхүүгийн хөрөнгө эсвэл бүлэг санхүүгийн хөрөнгүүд нь үнэ цэнийн бууралтад орсныг нотлох бодит нотолгоо байгаа эсэхийг санхүүгийн байдлын тайлангийн өдөр бүр үнэлж үзнэ.

Хэрэв хөрөнгийг анхлан хүлээн зөвшөөрсний дараа нэг буюу түүнээс олон тооны "Алдагдлын тохиолдол"-ын улмаас үнэ цэнийн бууралтын бодит нотолгоо бий болсон ба уг "Алдагдлын тохиолдол" нь санхүүгийн хөрөнгө эсвэл бүлэг санхүүгийн хөрөнгийн ойролцоолон тооцоолсон ирээдүйн мөнгөн урсгалд нөлөөлж байгаа үед санхүүгийн хөрөнгийг эсвэл бүлэг санхүүгийн хөрөнгийг үнэ цэнийнбууралтад орсон гэж үзнэ. Үнэ цэнийн бууралтын нотолгоонд зээлдэгч эсвэл бүлэг зээлдэгчид нь санхүүгийн томоохон хүндрэлд орсон, зээлийнхүү болон үндсэн төлбөр зөрчилд орсон, дампуурах эсвэл санхүүгийн өөр бусад дахин зохион байгуулалтад орох магадлалтай болсон, зөрчилтэй холбоотой эдийн засгийн нөхцөл байдалд гарсан өөрчлөлт гэх мэт тооцоолсон ирээдүйн мөнгөн урсгалд хэмжиж болохуйц бууралт байгааг харуулсан бодит өгөгдөл бий болох зэрэг орно.

*Хорогдуулсан өртгөөр нь бүртгэх санхүүгийн хөрөнгүүд*

Үнэ цэнийн бууралтын алдагдал гарсан талаар бодит нотолгоо байгаа бол алдагдлыг тухайн хөрөнгийн бүртгэлийн дүн ба ирээдүйд орж ирэхээр тооцоолсон мөнгөн урсгалын өнөөгийн үнэ цэнийн (бодитоор тохиолдоогүй ирээдүйд хүлээгдэж буй зээлийн алдагдлыг оруулахгүй) зөрүүгээр хэмжинэ. Орж ирнэ гэж тооцоолсон ирээдүйн мөнгөн урсгалын өнөөгийн үнэ цэнийг санхүүгийн хөрөнгийн анхны, үр ашигт хүүний хувиар бууруулан тооцдог. Зээлийн хүүний хувь нь хувьсах байх нөхцөлд үнэ цэнийн бууралтын алдагдлыг хэмжих хөнгөлөлтийн хувь нь өнөөгийн үр ашигт хүүний хувьтай тэнцүү байна.

Хөрөнгийн бүртгэлийн дүнг эрсдэлийн сангийн дансаар бууруулах ба алдагдлын дүнг орлого, үр дүнгийн тайланд хүлээн зөвшөөрнө. Бүртгэлийн бууруулсан дүн дээр хүүний орлогыг үргэлжлүүлэн хуримтлуулах ба үнэ цэнийн бууралтын алдагдлыг хэмжих зорилгоор ирээдүйн мөнгөн урсгалыг бууруулахад ашигласан хүүг ашиглан хуримтлуулна. Хүүний орлогыг санхүүгийн орлогын нэг хэсэг болгон орлого, зардлын дансанд бүртгэнэ. Цаашид эргэн төлөгдөх ямар нэг бодит чиг хандлага байхгүй байгаа, бүх барьцаа хөрөнгийг борлуулсан эсвэл Компанид шилжүүлсэн үед зээлийг холбогдох зээлийн эрсдэлийн сангийн хамт данснаас хасна.

SHONKHOR estimate & audit 01

## 2. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГУУД (ҮРГЭЛЖЛЭЛ)

### 2.1 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын товчоо (үргэлжлэл)

**ё. Санхүүгийн хөрөнгө (үргэлжлэл)**

*(iv) Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралт (үргэлжлэл)*

Хэрэв дараагийн тайлант хугацаанд үнэ цэнийн бууралтыг хүлээн зөвшөөрсний дараах үйл явдлын улмаас тооцоолсон үнэ цэнийн бууралтын алдагдал өсөж эсвэл буурвал, сангийн дансыг залруулах замаар өмнө хүлээн зөвшөөрсөн үнэ цэнийн бууралтыг өсгөж эсвэл бууруулна. Данснаас хассан хөрөнгө дараа нь эргэн төлөгдвөл дэлгэрэнгүй орлогын тайлангийн санхүүгийн зардал дансны кредитэд бүртгэнэ.

**ж. Санхүүгийн өр төлбөр**

*(i) Анхны хүлээн зөвшөөрөлт ба хэмжилт*

Санхүүгийн өр төлбөрийг аль зохистой ангилалд нь бодит үнэ цэнийн өөрчлөлт нь орлого, зарлагын дансанд бүртгэгдэх, зээл ба зээллэг, эсвэл үр нөлөөтэй хейджингийн хэрэглүүрээр анх хүлээн зөвшөөрнө

Бүх санхүүгийн өр төлбөрүүдийг анх бодит үнэ цэнээр хүлээн зөвшөөрөх ба зээл, зээллэг болон өр төлбөрийн хувьд шууд хамааралтай гүйлгээний зардлыг хассаны дараах дүнгээр хүлээн зөвшөөрнө.

Компанийн санхүүгийн өр төлбөрүүдэд дансны болон бусад өр төлбөр ба урьдчилж орсон орлого орно. Санхүүгийн өр төлбөрүүдийн хэмжилт дор дурдсан ангиллаас хамаарна:

*Зээл, зээллэг ба хойшлогдсон орлогын өр төлбөр*

Анххэмжсэнийдараа, зээллэгүүд, хойшлогдсон орлогын өр төлбөр, хүүгийнөглөг, дансны болон бусад өглөгийг дараагийн тайлант хугацаанд үр ашигт хүүний аргыг ашиглан хорогдуулсан өртгөөр нь хэмжинэ. Өр төлбөрийг үл хүлээн зөвшөөрөх үед болон үр ашигт хүүг ашиглан хорогдуулах үеийн олз, гарзыг орлого, зардлын дансанд хүлээн зөвшөөрнө.

Хорогдуулсан өртгийг үр ашигт хүүний салшгүй хэсэг болох зээл олголтын урамшуулал, хөнгөлөлт болон шимтгэл, холбоотой зардлуудыг оролцуулан тооцдог. Үр ашигт хүүгийн хорогдуулалт нь дэлгэрэнгүй орлогын тайлангийн санхүүгийн зардалд багтана.

*(ii) Үл хүлээн зөвшөөрөлт*

Санхүүгийн өр төлбөрийг төлөхөөс чөлөөлөгдсөн, өр төлбөр цуцлагдсан эсвэл хугацаа нь дууссан бол үл хүлээн зөвшөөрдөг. Хэрэв одоо байгаа санхүүгийн өр төлбөрийн зээлдүүлэгч нь хэвээрээ боловч ялгаатай нөхцөлтэй зээлийн гэрээгээр сольсон эсвэл одоо байгаа зээлийн нөхцөл эрс өөрчлөгдсөн бол эдгээр өөрчлөлт шинэчлэлтийг анхны санхүүгийн өр төлбөрийн үл хүлээн зөвшөөрөлт ба шинэ өр төлбөрийн хүлээн зөвшөөрөлт гэж үзэх ба бүртгэлийн дүнгийн зөрүүг орлого, зардлын дансанд хүлээн зөвшөөрнө.

SHONKHOR estimate & audit 01

## 2. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГУУД (ҮРГЭЛЖЛЭЛ)

### 2.1 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын товчоо (үргэлжлэл)

#### з. Санхүүгийн хэрэглүүрүүдийг цэвэршүүлэх

Хэрэв байгууллага хүлээн зөвшөөрсөн дүнгүүдийг цэвэршүүлэх хуулиар олгогдсон эрхтэй, тооцоог цэвэр дүнгээр нь барагдуулах, эсвэл хөрөнгийг борлуулж өр төлбөрийг нь барагдуулах ажлыг нэгэн зэрэг хийхээр зэхэж байгаа л бол санхүүгийн хөрөнгө ба өр төлбөрүүдийг хооронд нь цэвэршүүлэн, цэвэр дүнгээр тайлан тэнцэлд толилуулах эрхтэй.

#### и. Бодит үнэ цэнээрх хэмжилт

Хэмжилтийн өдөр зах зээлийн оролцогчдын хооронд зохих журмын дагуу хийгдэж буй гүйлгээний үед хөрөнгө борлуулахад хүлээн авч буй эсвэл өр төлбөрийг шилжүүлэхэд төлж буй үнийг бодит үнэ цэнэ гэнэ. Бодит үнэ цэнийн хэмжилт нь дараах тохиолдлуудад болж буй хөрөнгийг борлуулах болон өр төлбөрийг шилжүүлэх гүйлгээний таамаглалд үндэслэдэг. Үүнд:

- Хөрөнгө, өр төлбөрийн үндсэн зах зээлд эсвэл
- Үндсэн зах зээл байхгүй үед хөрөнгө, өр төлбөрийн хамгийн давуу зах зээлд

Компани үндсэн болон давуу зах зээлд оролцох боломжтой байх ёстой.

Зах зээлийн оролцогчид нь хөрөнгө, өр төлбөрийн үнийг тогтоох үед өөртөө эдийн засгийн хувьд хамгийн ашигтай байхаар оролцоно гэсэн төсөөллийг ашиглан хөрөнгө болон өр төлбөрийн бодит үнэ цэнийг хэмжинэ.

Санхүүгийн бус хөрөнгийн бодит үнэ цэнийн хэмжилтэд хөрөнгийг хамгийн үр ашигтайгаар ашиглаж эсвэл хөрөнгийг хамгийн үр ашигтайгаар ашиглах зах зээлийн өөр нэг оролцогчид хөрөнгийг борлуулснаар эдийн засгийн өгөөжийг бий болгох зах зээлийн оролцогчийн чадварыг харгалзаж үзнэ.

Компани тухайн нөхцөлд тохирох үнэлгээний техникүүдийг ашиглах ба уг нөхцөл нь бодит үнэ цэнийг хэмжихэд шаардагдах хангалттай мэдээлэлтэй, холбогдох ажиглаж болохуйц орцуудыг дээд зэргээр, ажиглах боломжгүй орцуудыг хамгийн багаар ашиглана.

Санхүүгийн тайланд хэмжиж, тодруулсан бүх хөрөнгө болон өр төлбөрүүдийг бодит үнэ цэнийн түвшинд дараах байдлаар ангилсан ба ангилахдаа бодит үнэ цэнийн хэмжүүрт бүхлээрээ томоохон нөлөөтэй хамгийн бага түвшний орцод үндэслэсэн:

- Түвшин 1 - хөрөнгө, өр төлбөрийн хөрөнгийн бирж дээр бүртгэлтэй (залруулаагүй), идэвхтэй зах зээл дээрх үнэ,
- Түвшин 2 - шууд болон шууд бусаар ажиглах боломжтой хамгийн бага түвшний орцууд нь бодит үнэ цэнэд томоохон нөлөө үзүүлэх үнэлгээний техникүүд
- Түвшин 3 - ажиглах боломжгүй хамгийн бага түвшний орц нь бодит үнэ цэнийн хэмжилтэд томоохон нөлөөтэй үнэлгээний техникүүд

SHONKHOR 01
estimate & audit

## 2. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГУУД (ҮРГЭЛЖЛЭЛ)

### 2.1 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын товчоо (үргэлжлэл)

#### и. Бодит үнэ цэнээрх хэмжилт (үргэлжлэл)

Компани санхүүгийн тайланд байнгын сууриар хүлээн зөвшөөрдөг хөрөнгө болон өр төлбөрүүдийн хувьд тайлант үе бүрийн эцэст ангиллыг дахин үнэлж (бүхлээрээ бодит үнэ цэнийн хэмжилтэд томоохон нөлөөтэй хамгийн бага түвшний оролцоо суурилан) үзсэнээр түвшний хоорондын шилжилт гарсан эсэхийг тодорхойлдог.

#### й. Урьдчилж төлсөн төлбөрүүд

Урьдчилж төлсөн төлбөр нь урьдчилж бэлэн мөнгө төлсөн боловч бодитоор гараагүй байгаа зардлуудыг хэлнэ. Урьдчилж төлсөн төлбөрүүд нь эхлээд хөрөнгө хэсэгт бүртгэгдэх ба төлсөн бэлэн мөнгөний дүнгээр хэмжигдэнэ. Үүний дараа үйл ажиллагаанд хэрэглэгдсэн буюу хугацаа нь дуусахад орлогын тайланд тусгагддаг.

#### к. Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийг анхны өртгөөс хуримтлагдсан элэгдэл ба хуримтлагдсан үнэ цэнийн бууралтын алдагдлыг хассан дүнгээр илэрхийлдэг. Үндсэн хөрөнгөөр хүлээн зөвшөөрөх шаардлагууд хангагдсан тохиолдолд л тухайн үндсэн хөрөнгийн сольсон хэсгийн өртөг болон зээллэгийн өртгийг тухай бүрд нь энэ өртөгт оруулна. Бусад бүх засвар үйлчилгээний зардлыг гарсан үед нь ашиг алдагдлын тайланд тусгана.

Хөрөнгийн ашиглалт дууссэн эсвэл өртөг болон холбогдох хуримтлагдсан элэгдэл болон үнэ цэнийн бууралт нь данснаас хасагдахад үүсэх олз болон гарз нь ашиг алдагдалд кредитлэгдэнэ.
Хүлээн зөвшөөрсний дараах үед үндсэн хөрөнгийг хуримтлагдсан элэгдэл ба хуримтлагдсан үнэ цэнийн бууралтын алдагдлыг хассан бодит үнэ цэнээр илэрхийлдэг.

Үндсэн хөрөнгийн элэгдлийг татварын зорилгоор шулуун шугамын аргаар, дараах ашиглалтын хугацаанд элэгдүүлнэ. Үүнд:

| Ангилал | Жил |
|---|---|
| Тавилга, оффисын тоног төхөөрөмж болон тээврийн хэрэгсэл | 10 жил |
| Компьютер ба техник тоног төхөөрөмж | 3 жил |
| Оффисийн түрээсийн сайжруулалт | 5 жил |

SHONKHOR estimate & audit 01

## 2. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГУУД (ҮРГЭЛЖЛЭЛ)

### 2.1 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын товчоо (үргэлжлэл)

#### к. Үндсэн хөрөнгө (үргэлжлэл)

Үндсэн хөрөнгийг худалдан борлуулах үед эсвэл түүний ашиглалт, борлуулалтаас ирээдүйд эдийн засгийн үр ашиг хүлээгдэхгүй болсон үед үл хүлээн зөвшөөрнө. Хөрөнгийн үл хүлээн зөвшөөрөлттэй холбогдон үүссэн аливаа олз, гарзыг (хөрөнгө борлуулалтын цэвэр орлого ба бүртгэлийн дүн хоёрын зөрүүгээр тооцно) хөрөнгийг үл хүлээн зөвшөөрсөн тайлант жилийн орлого, үр дүнгийн тайланд тусгана.

Үндсэн хөрөнгийн үлдэх өртөг, ашиглалтын хугацаа, элэгдлийн арга нь өмнө хийгдсэн тооцоолол ба үндсэн хөрөнгөнд агуулагдаж буй ирээдүйн эдийн засгийн үр ашгийн хүлээгдэж буй хэрэглээний хэв загварт нийцэж байгаа эсэхийг баталгаажуулах үүднээс үндсэн хөрөнгийн үлдэх өртөг, ашиглалтын хугацаа, элэгдлийн аргыг санхүүгийн жилийн эцэс бүрд хянаж үздэг.

#### л. Биет бус хөрөнгө

Тусад нь авсан биет бус хөрөнгийг анх хүлээн зөвшөөрөхдөө өртгөөр нь бүртгэдэг. Бизнес нэгдлийн үед авсан биет бус хөрөнгийг авсан өдрийн бодит үнэ цэнээр бүртгэнэ. Анх хүлээн зөвшөөрсний дараа биет бус хөрөнгийг хуримтлагдсан хорогдуулалт болон үнэ цэнэ бууралтын алдагдлыг хассан өртгөөр нь тайланд тусгадаг.

Дотооддоо хөгжүүлсэн биет бус хөрөнгийн хувьд хөгжүүлэлтийн зардлаас бусад зардал өртгийг нэмэгдүүлэхгүй. Үүний оронд холбогдох зардлуудыг зардал гарсан тайлант хугацаанд олз, гарзаар бүртгэнэ.

Биет бус хөрөнгийн ашиглалтын хугацаа нь тодорхой эсвэл тодорхой бус эсэхийг үнэлнэ. Компанийн эзэмшиж байгаа бүх биет бус хөрөнгүүд нь тодорхой ашиглалтын хугацаатай.

Ашиглалтын тодорхой хугацаатай биет бус хөрөнгийг эдийн засгийн үр ашигтай хугацааны туршид нь хорогдуулах ба үнэ цэнийн бууралтын шинж тэмдэг илэрсэн тухай бүрд үнэ цэнийн бууралтын үнэлгээ хийнэ. Ашиглалтын тодорхой хугацаатай биет бус хөрөнгийн хорогдуулах хугацаа болон аргыг хамгийн багадаа санхүүгийн жил бүрийн эцэст хянаж үздэг. Хүлээгдэж буй ашиглалтын хугацаа эсвэл хүлээгдэж буй ирээдүйн үр өгөөжийн хэв загварт орсон өөрчлөлтийг хорогдуулалтын хугацаа эсвэл аргын аль тохиромжтойг нь өөрчлөх замаар бүртгэлд тусгах ба уг өөрчлөлтийг нягтлан бодох бүртгэлийн тооцооллын өөрчлөлт гэж үзнэ.

Хязгаарлагдмал хугацаатай биет бус хөрөнгийн хорогдуулалтын зардлыг дэлгэрэнгүй орлогын тайланд биет бус хөрөнгийн үүрэгтэй нь нийцсэн зардлын бүлэгт хүлээн зөвшөөрнө.

SHONKHOR consulting & audit 01

## 2. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГУУД (ҮРГЭЛЖЛЭЛ)

### 2.1 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын товчоо (үргэлжлэл)

#### л. Биет бус хөрөнгө (үргэлжлэл)

Биет бус хөрөнгийг үл хүлээн зөвшөөрөхтэй холбоотой үүссэн аливаа нэг олз, гарзыг (хөрөнгийн борлуулалтын цэвэр орлого ба бүртгэлийн дүн хоёрын зөрүүгээр тооцно) тухайн тайлант жилийн орлого, үр дүнгийн тайланд тусгана.

Компанийн биет бус хөрөнгө нь нягтлан бодох бүртгэлийн програм хангамж бөгөөд шулуун шугамын аргыг ашиглан гурван (3) жил хорогдуулна.

#### м. Өөрийн хөрөнгө

Энгийн хувьцааг өөрийн хөрөнгөнд ангилна. Энгийн хувьцааны ногдол ашгийг зарласан үедээ өөрийн хөрөнгөнд хүлээн зөвшөөрдөг. Өөрийн хөрөнгийн гүйлгээтэй холбоотой гүйлгээний зардлыг татвар суутгасан дүнгээр нь өөрийн хөрөнгөнөөс хасна. Өөрийн хөрөнгийн гүйлгээний өртөгт зөвхөн өөрийн хөрөнгийн гүйлгээнд шууд холбоотой гадны нэмэгдүүлсэн өртгөөс бусад өртгийг оруулахгүй.

#### н. Холбоотой талуудын гүйлгээ

Холбоотой тал гэдэг нь Компанитай холбоотой хувь хүн эсвэл байгууллага байна.

(а) Хувь хүн эсвэл тухайн хүний гэр бүлийн ойрын гишүүн доорх шаардлагуудыг хангасан тохиолдолд Компанийн холбоотой талд тооцогдоно. Үүнд:

- (i) Компанийн хяналт болон хамтын хяналт байдаг бол;
- (ii) Компанид томоохон нөлөөлөл байдаг бол;
- (iii) Компанийн гол удирдах ажилтан эсвэл Компанийн толгой компанийн гишүүн бол.

(б) Аж ахуйн нэгж байгууллага нь доорх шаардлагуудыг хангасан тохиолдолд Компанийн холбоотой талд тооцогдоно. Үүнд:

- (i) Компани болон аж ахуйн нэгж нь нэг группын гишүүд бол (өөрөөр хэлбэл толгой компани, охин компани ба зэргэлдээ охин компани бүр нь хоорондоо холбоотой юм);

SHONKHOR estimate & audit 01

## 2. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГУУД (ҮРГЭЛЖЛЭЛ)

### 2.1 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын товчоо (үргэлжлэл)

**н. Холбоотой талуудын гүйлгээ**

(б) Аж ахуйн нэгж байгууллага нь доорх шаардлагуудыг хангасан тохиолдолд Компанийн холбоотой талд тооцогдоно. Үүнд:

(ii) нэг байгууллага нь нөгөө байгууллагын хараат компани эсвэл хамтын үйлдвэр бол (эсвэл, өөр байгууллага нь гишүүн байх компанийн хараат компани эсвэл хамтын үйлдвэрийн гишүүнбол);

(iii) хоёр компани хоёулаа нэг гуравдагч талын хамтын үйлдвэр бол;

(iv) нэгтал нь нөгөө талын хараат компани эсвэл хамтын үйлдвэр бол (эсвэл, нөгөө тал нь гишүүн байх компанийн хараат компани эсвэл хамтын үйлдвэрийн гишүүн бол);

(v) байгууллага нь Компанийн эсвэл Компанитай холбоотой талын ажилчдын тэтгэмжтэй холбоотой ажлаас гарсны дараах тэтгэмжийн хөтөлбөр бол. Хэрвээ Компани өөрөө тэр хөтөлбөр бол, ажил олгогчийн спонсор нь мөн Компанитай холбоотой тал болно;

(vi) (а)-д заасан хувь хүнд байгууллагын хяналт эсвэл хамтын хяналт байдаг бол;

(vii) (а)(i)-д заасан хувь хүнд байгууллагын томоохон нөлөө байх эсвэл тухайн хүн нь компанийн гол удирдах ажилтан бол (эсвэл толгой компанийн);

(viii) Компанид эсвэл Компанийн толгой компанид гол удирдах ажилтанаар хангах үйлчилгээ үзүүлдэг байгууллага эсвэл группийн ямарваа гишүүн бол.

## 3. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ ҮНЭЛЭМЖ БА ТООЦООЛОЛ

Компанийн санхүүгийн тайлангуудыг бэлтгэх ажил нь удирдлагаас тайлагналын өдрийн байдлаарх хөрөнгө, өр төлбөр, болзошгүй өр төлбөр, тайлант үеийн орлого, зардалд тайлагнасан дүнд нөлөө үзүүлэх үнэлэмж, ойролцоолсон тооцоолол, төсөөллүүдийг хийхийг шаарддаг.Эдгээр төсөөлөл, тооцооллуудын тодорхой бус байдал нь ирээдүйд хөрөнгө, өр төлбөрийн бүртгэлийн дүнд материаллаг дүнтэй залруулга хийхэд хүргэж болно. Тухайлбал, санхүүгийн тайлан бэлтгэхэд удирдлагын авч үзсэн томоохон тооцооллын тухай мэдээллийг дор үзүүлэв:

*Бусад авлагын үнэ цэнийн бууралтыг тооцоолох*
Компани нь ирээдүйд авлагаас учрах боломжит алдагдлын хэмжээгээр үнэ цэнэ бууралтын сан байгуулдаг. Энэхүү сангийн дүн нь удирдлагын түүхэн туршлага болон бусад эргэн төлөлтөд нөлөөлөхүйц хүчин зүйлүүдийн үнэлэмжээс шалтгаална. Тиймээс аль ч тайлант хугацаанд бүртгэсэн үнэ цэнийн бууралтын зардал нь тухайн жилийн үнэлэмж, тооцоолол болон төсөөллөөс хамааран өөрчлөгдөж байдаг.

SHONKHOR 01
consulting & audit

*/мян.төг/*

## 4. МӨНГӨ ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ

| | 2024.12.31 | 2023.12.31 |
|---|---|---|
| Касст байгаа бэлэн мөнгө (төгрөг) | 878 | 295 |
| Харилцах данс (төгрөг) | 2,952,860 | 2,235,769 |
| Харилцах данс (төгрөг) ТЗК | 156,885 | 21,301 |
| Харилцах данс (төгрөг) СМЭ | 100,283 | - |
| Харилцах данс (доллар) | 171,358 | 892,708 |
| Харилцах данс (евро) | 64 | 80 |
| Цахим хэтэвч | 503,360 | 1,679,995 |
| Нийт дүн | **3,885,688** | **4,830,148** |
| Хадгаламж төгрөг | 7,007,169 | 1,001,011 |
| Хадгаламж доллар | 1,813,217 | 2,054,808 |
| Нийт хадгаламж | **8,820,386** | **3,055,819** |
| **Нийт мөнгө, мөнгөтэй адилтгах** | **12,706,074** | **7,885,967** |

Банкны үлдэгдэл дэх бэлэн мөнгө гэдэг нь Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй арилжааны банкуудад байршуулсан харилцах дансууд бөгөөд барьцаагүй байна.
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн дансны үнэ нь бодит үнэ цэнэтэй ойролцоо байна. Харилцах данс дах долларыг 3,420.25, еврог 3,561.04 төгрөгөөр тус тус тооцож шилжүүлсэн.

## 5. ДАНСНЫ АВЛАГА

| | 2024.12.31 | 2023.12.31 |
|---|---|---|
| Хэвийн авлага | 297,059 | 226,290 |
| Ажиллагсадаас авах авлага | 1,565 | 1,565 |
| Барьцаа хөрөнгийн авлага | 184,944 | 67,026 |
| Хойшлогдсон татварын авлага | 180,977 | 41,318 |
| Түр зээл | 4,740 | 25,258 |
| Хөрөнгө хураахтай холбоотой | 48,628 | 15,114 |
| **Нийт авлага** | **717,913** | **376,571** |

## 6. БУСАД АВЛАГА

| | 2024.12.31 | 2023.12.31 |
|---|---|---|
| Бодит үнэ цэнээр илэрхийлсэн санхүүгийн хөрөнгө | 1,094,548 | - |

SHONKHOR estimate & audit

*/мян.төг/*

## 7. ХАРИЛЦАГЧДАД ОЛГОСОН ЗЭЭЛ БОЛОН УРЬДЧИЛГАА

| | 2024.12.31 | 2023.12.31 |
|---|---|---|
| Хэвийн зээл | 221,574,121 | 116,268,031 |
| Хугацаа хэтэрсэн зээл | 6,025,605 | 3,961,259 |
| Чанаргүй зээл | 10,182,882 | 5,161,768 |
| Хэвийн бус зээл | 4,018,256 | 1,827,118 |
| Эргэлзээтэй зээл | 3,106,629 | 1,730,422 |
| Муу зээл | 3,057,997 | 1,604,228 |
| Нийт зээл | 237,782,608 | 125,391,057 |
| Зээлийн эрсдлийн сан | 13,193,203 | 5,666,922 |
| Цэвэр зээл | 224,589,405 | 119,724,135 |
| Хуримтлагдсан зээлийн хүү | 7,138,162 | 3,738,238 |
| **Нийт зээл болон хүү** | **231,727,567** | **123,462,373** |

Компанийн бизнес загварын дагуу ЛэндМН технологийг ашиглан зээл авсан зээлдэгчид нь богино хугацаанд санхүүгийн хэрэглээгээ санхүүжүүлэх зорилготой хувь хүмүүс байдаг.

Компани нь 2021 оноос эхлэн ЛэндМН аппликейшнд зээлийн түүх нь шаардлага хангасан харилцагчдад автомашины зээлийг олгож эхэлсэн. Автомашины зээлүүд нь зээлээр худалдан авсан автомашинуудыг барьцаалсан байна.

2023 оны 4-р сард Компани нь 5-50 сая төгрөгийн лимит бүхий шинэ зээлийн бүтээгдэхүүнийг гаргасан.Уг бүтээгдэхүүн нь харилцагчдын дунд хугацааны санхүүгийн хэрэгцээг хангахад зориулагдсан ба зээлдэгчийн сүүлийн 2 жилийн зээлийн түүх нь сайн байх шаардлагатай юм.

Групп 2024 оны 2-р сард ЖДҮ эрхлэгчдэд тусгайлан зориулсан бизнесийн зээлийн шинэ бүтээгдэхүүн гаргасан. Энэхүү зээлийн бүтээгдэхүүн нь 5 сая төгрөгөөс 100 сая төгрөг хүртэлх зээлийн уян хатан нөхцөлөөр бизнес эрхлэгчдийн санхүүгийн хэрэгцээг хангах зорилготой юм. Зээлдэгчдэд тавигдах зээлийн шалгуур нь эргэлтийн зээлд хэрэглэх шалгууртай адил байна.

## 8. ХУРИМТЛУУЛСАН ЗЭЭЛИЙН ХҮҮГИЙН АВЛАГА

| | 2024.12.31 | 2023.12.31 |
|---|---|---|
| Зээлийн хүүгийн авлага | 6,764,834 | 3,297,965 |
| Хуримтлуулсан шимтгэлийн авлага | 373,328 | 440,273 |
| **Нийт хүүгийн авлага** | **7,138,162** | **3,738,238** |

SHONKHOR estimate & audit 01

*/мян.төг/*

| **Зээлийн төрөл** | **2024.12.31** | **2023.12.31** |
|---|---|---|
| Хэрэглээний зээл | 240,373,524 | 123,659,805 |
| Бизнесийн үйл ажиллагаанд зориулсан зээл | 1,573,762 | 130,034 |
| Автомашин худалдан авахад зориулсан зээл | 2,973,484 | 5,339,456 |
| **Нийт зээл** | **244,920,770** | **129,129,295** |
| Зээлийн эрсдлийн сан | (13,193,203) | (5,666,922) |
| Нийт зээл болон урьдчилгаа | **231,727,567** | **123,462,373** |

| | **2024** | **2023** |
|---|---|---|
| Шатлал 1 | 225,877,266 | 119,732,242 |
| Шатлал 2 | 11,210,963 | 3,751,139 |
| Шатлал 3 | 7,832,541 | 5,645,914 |
| Хасах нь: ЗҮЦХА-ын сан | (13,193,203) | (5,666,922) |
| Цэвэр зээлийн багц | **231,727,567** | **123,462,373** |

Компани нь харилцагчдад олгосон зээл болон урьдчилгааны үнэ цэнийн бууралтын алдагдлыг СТОУС 9-ийн дагуу тооцоолсон. Ерөнхий аргачлалын дагуу зээлийн багцаа Шатлал 1, 2 болон 3 гэж дараах байдлаар ангилж, магадлалаар жигнэсэн ирээдүйг таамагласан ЧМ болон АХЧ-ыг шатлал тус бүрт тооцоолсон.

Шатлал 1: Хэвийн зээлийн багц болон + 31-ээс бага хоног хугацаа хэтэрсэн зээлийн багц

Шатлал 2: 31-90 хоног хугацаа хэтэрсэн зээлийн багц

Шатлал 3: 90-ээс дээш хоног хугацаа хэтэрсэн зээлийн багц

Харилцагчдад олгосон зээл болон урьдчилгааны нийт дансны дүн болон холбогдох ЗҮЦХА-ын сангийн өөрчлөлтийн дэлгэрэнгүйг дор үзүүлэв:

SHONKHOR estimate & audit

*/мян.төг/*

2024 оны хувьд үе шат хооронд шилжсэн шилжилтийг хүснэгтээр харуулья

| | **Шатлал 1** | **Шатлал 2** | **Шатлал 3** | **Нийт** |
|---|---|---|---|---|
| 2024 оны 1-р сарын 1-нээрх зээлийн дансны үнэ | **119,732,242** | **3,751,139** | **5,645,914** | **129,129,295** |
| Шинээр олгосон эсвэл худалдан авсан зээл | 1,026,392,899 | 14,457,829 | 5,772,070 | 1,046,622,798 |
| Хасагдсан Данснаас хассан/Сангаас хаасан | (920,247,875) | (6,998,005) | (3,585,443) | (930,831,323) |
| 2024 оны 12-р сары 31 нээрх зээлийн дансны үнэ | **225,877,266** | **11,210,963** | **7,832,541** | **244,920,770** |

| | **Шатлал 1** | **Шатлал 2** | **Шатлал 3** | **Нийт** |
|---|---|---|---|---|
| 2023 оны 1-р сарын 1-нээрх зээлийн дансны үнэ | 68,302,290 | 1,450,756 | 3,130,360 | 72,883,406 |
| Шинээр олгосон эсвэл худалдан авсан зээл | 662,385,713 | - | - | 662,385,713 |
| Үл хүлээн зөвшөөрсөн эсвэл эргэн төлөгдсөн зээл | (585,755,920) | (12,295,033) | (7,759,297) | (605,810,250) |
| Шатлал 2-т орсон шилжилт | (28,664,052) | 25,199,841 | - | - |
| Шатлал 3-т орсон шилжилт | - | (10,604,42) | 10,604,425 | - |
| Данснаас хассан | - | - | (329,574) | (329,574) |
| 2023 оны 12-р сарын 31нээрх зээлийн дансны үнэ | **119,732,242** | **3,751,139** | **5,645,914** | **129,129,295** |

Харилцагчдад олгосон зээл болон урьдчилгааны үнэ цэнийн бууралтын сангийн хөдөлгөөнийг дор үзүүлэв:

| | **2024.12.31** | **2023.12.31** |
|---|---|---|
| 1 дүгээр сарын 1-ний байдлаар | 5,666,922 | 3,297,126 |
| Тайлант жилд байгуулсан | 8,157,556 | 2,699,370 |
| Тайлант жилд данснаас хассан | (631,275) | (329,574) |
| 12 дугаар сарын 31-ний байдлаар | **13,193,203** | **5,666,922** |

"Банк бус санхүүгийн байгууллагын зээлийн активыг ангилах, активын эрсдлийн сан байгуулж, зарцуулах" журмыг СЗХ-ны дарга болон Сангийн сайдын 2015 оны 5 дугаар сарын 13-ны өдрийн 145/124 тоот хамтарсан тушаалаар баталсан. Уг журмын дагуу олгосон зээлийг хугацаа хэтэрсэн хоногоос хамааран 5 ангилах ба ангилал тус бүрт урьдчилан тогтоосон, тогтмол хувиар үнэ цэнийн бууралтын санг тооцоолдог ба мөн үе шатуудад ангилж үздэг байна.

SHONKHOR estimate & audit 01

*/мян.төг/*

Компани нь зээлийн эрсдийн санг тооцохдоо түүхэн дата болон эдийн засгийн үзүүлэлтүүийг авч үздэг ба зээлийн багцийг 3 үе шатаар ангилдаг. 0-30 хоног хугацаа хэтэрсэн зээлийг үе шат 1, 31-90 хоног хугацаа хэтэрсэн зээлийг үе шат 2, 91-с дээш хугацаа хэтэрсэн зээлийг үе шат 3-т тус тус ангилан шатлал бүрд ирээдүйд эрсдэх магадлал болон төлөгдөхгүй байх магадлалын хувиар тооцдог.

## 9. БАРАА МАТЕРИАЛ

| | 2024.12.31 | 2023.12.31 |
|---|---|---|
| Хангамжийн материал | 4,116 | 15,613 |

## 10. УРЬДЧИЛЖ ТӨЛСӨН ЗАРДАЛ ТООЦОО

| | 2024.12.31 | 2023.12.31 |
|---|---|---|
| Урьдчилж төлсөн тооцоо | 392,103 | 55,821 |
| Урьдчилж төлсөн тооцоо ТЗК | - | 154 |
| | **392,103** | **55,975** |

## 11. ӨМЧЛӨХ БУСАД ХӨДЛӨХ ХӨРӨНГӨ

| | 2024.12.31 | 2023.12.31 |
|---|---|---|
| | 11,000 | 15,080 |

SHONKHOR 01 estimate & audit

*/мян.төг/*

## 12. БИЕТ БУС ХӨРӨНГӨ

| | 2024.12.31 | 2023.12.31 |
|---|---|---|
| **Өртөг** | | |
| 12-р сарын 31-ний байдлаар | 900,608 | 610,818 |
| | | |
| **Хуримтлагдсан элэгдэл** | | |
| 1-р сарын 1-ний байдлаар | 100,552 | 209,723 |
| Тайлант жилийн өөрчлөлт | 45,383 | 45,553 |
| 12-р сарын 31-ний байдлаар | 145,935 | 255,276 |
| | | |
| Дансны цэвэр дүн | **754,673** | **355,542** |

Компанийн биет бус хөрөнгө нь зэргэлдээ охин компани болох Анд Системс Тех-ээс худалдаж авсан зээлийн үйл ажиллагаа явуулах болон хэтэвчний гүйлгээ хийх зориулалт бүхий Монгол Улсын нутаг дэвсгэрт ашиглах ЛэндМН технологийн тусгай эрхийн лицензээс бүрдэнэ. Харилцагч бүртгэх, харилцагч үнэлэх, зээлийн шийдвэр гаргах, зээл олгох, төлөлт хийх, тайлагнах, харилцагчид техникийн тусламж үйлчилгээ үзүүлэх модулиуд болон ЛэндМН аппликэйшнээс бүрдэх ЛэндМН зээлийн технологийн лицензийг анх 2016 оны 12 сард Анд Системс Тех-ээс худалдан авсан.

Талууд харилцан тохиролцсон эсвэл Компанийн зээл олгох тусгай зөвшөөрөл цуцлагдсанаас бусал тохиолдол дээр дурдсан хоёр тусгай эрхийг эзэмших гэрээнүүд цуцлагдахгүи. Лицензиин хугацаа хэдиигээр 50 жил боловч удирдлага лицензийн ашиглалтын хугацааг 10 жил гэж дүгнэж байгаа тул ЛэндМН технологийн лицензийг 10 жилээр, цахим хэтэвч аппликэйшныг ЛэндМН технологийн лицензийн үлдсэн ашиглалтын хугацаанд хорогдуулан бүртгэсэн.

Групп нь 2024 онд гар утасны зээлийн аппликейшн болон PLUS аппликейшны нэмэлт шинэчлэлтийн төлбөрийг 231,396 мянган төгрөг, 213,118 мянган төгрөгийг холбогдох этгээдэд төлсөн. Хоёр шинэчлэлтийг 10 жилийн хугацаанд хорогдуулдаг.

*/мян.төг/*

## 13. ҮНДСЭН ХӨРӨНГӨ

| | Түрээсийн байрны сайжруулалт | Авто машин | Компьютер техник хэрэгсэл | Тавилга эд хогшил | Бусад хөрөнгө | Нийт |
|---|---|---|---|---|---|---|
| **Өртөг** | | | | | | |
| 2023 оны 01-р сарын 01 | 1,149,312 | 197,760 | 397,678 | 104,755 | 69,670 | 1,919,175 |
| Нэмэгдсэн | 3,476,210 | - | 189,879 | 188,835 | 1,009,717 | 4,864,641 |
| Хасагдсан | 888,979 | - | 51,682 | 91,552 | 74,209 | 1,106,422 |
| **2023 оны 12-р сарын 31** | 3,736,543 | 197,760 | 535,875 | 202,038 | 1,005,178 | 5,677,394 |
| **Хуримтлагдсан элэгдэл** | | | | | | |
| 2023 оны 01-р сарын 01 | 203,659 | 82,725 | 274,606 | 42,340 | 64,033 | 667,363 |
| Тухайн жилийн элэгдэл | 697,662 | 19,814 | 91,709 | 11,723 | 10,175 | 831,083 |
| Шилжүүлсэн элэгдэл | 597,526 | - | 51,630 | 40,566 | 74,208 | 763,930 |
| 2023 оны 12-р сарын 31 | 303,795 | 102,539 | 314,685 | 13,497 | - | 734,516 |
| **Цэвэр хөрөнгө** | **3,432,748** | **95,221** | **221,190** | **188,541** | **1,005,178** | **4,942,878** |

Оффисын байрын түрээсийн гэрээг ашиглах эрхтэй хөрөнгөөр бүртгэн элэгдүүлж элэгдлийн зардлыг тайлант үеийн татвар ногдох орлогоос үечилсэн байдлаар хасагдах зардал болгодог.

*/мян.төг/*

## 14. ТАТВАРЫН ӨГЛӨГ

| | 2024.12.31 | 2023.12.31 |
|---|---|---|
| ААНОАТ өр | 3,566,405 | 4,070,018 |
| НӨАТ-ын өр | 17,751 | 10,464 |
| ХХОАТ-ын өр | 460,412 | - |
| Бусад татварын өр | 234,824 | - |
| | **4,279,392** | **4,080,482** |

## 15. БОГИНО ХУГАЦААТ ЗЭЭЛ

| | 2024.12.31 | 2023.12.31 |
|---|---|---|
| Банк, санхүүгийн байгууллагаас авсан зээл | 75,329,520 | 8,124,018 |

## 16. ИТГЭЛЦЭЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ӨГЛӨГ

| | 2024.12.31 | 2023.12.31 |
|---|---|---|
| Итгэлцлийн өглөг | 62,594,178 | 35,661,746 |

1. Групп нь 2022 оны 4-р сарын 4-ний өдөр тус бүр нь 100,000 төгрөгийн нэрлэсэн үнэтэй, хагас жил тутамд жилийн 15%-ийн хүүтэй 31,000 ширхэг бондыг олон нийтэд гаргасан бгөөд 2024 оны 4-р сарын 3-ны өдөр дуусгавар болсон.

   Групп нь 2023 оны 9-р сарын 8-ны өдөр тус бүр нь 100,000 төгрөгийн нэрлэсэн үнэтэй, жилийн 18.0%-ийн хүүтэй, улирал тутамд хүү төлөгдөх 90,000 ширхэг бондыг олон нийтэд гаргасан. Уг бондыг толгой компанийн Групп дэх хувьцаагаар барьцаалсан бөгөөд 2025 оны 9-р сарын 7-нд дуусгавар болно.

   Групп нь 2024 онд тус бүр нь 100,000 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 200,000 ширхэг бонд гаргаж, жилийн 18,0%-18,5%-ийн хүүтэй. Энэхүү олголт нь 2 жилийн хугацаатай бөгөөд 10 үе шаттайгаар хийгдсэн.

2. Групп нь 2021 онд "Анд Системс ХХК"-иас 2,845,000 мянган төгрөгийн хоёрдогч өрийг жилийн 14 хувийн хүүтэй, 5 жилийн хугацаатай хүүтэй авсан.

3. Групп нь 2022 оны 12-р сарын 30-ны өдөр "Анд Системс ХХК"-аас жилийн 18.0%-ийн хүүтэй, 1 жилийн хугацаатай 10,000,000 мянган төгрөгийн зээл авсан. 2023 оны 10 дугаар сард энэхүү зээлийн нөхцөлийг өөрчилж, жилийн хүүг 19.0% болгон нэмэгдүүлж, хугацааг 2025 оны 10 дугаар сар хүртэл сунгаж, 2024 онд зээлийн хязгаарыг 10,000,000 төгрөгөөс 20,000,000 төгрөг болгон нэмэгдүүлсэн.

4. Групп нь 2024 оны 12-р сарын 31-ний байдлаар арилжааны банкуудад 36,679,317 мянган төгрөгийн зээлийн өрийн үлдэгдэлтэй байна. Эдгээр зээлийн дансны үнэ 57,809,603 мянган төгрөг, банкны хадгаламжийн 57,809,603.0 мянган төгрөгийг харилцагчдад олгосон зээл, урьдчилгаагаар барьцаалсан байна.

SHONKHOR estimate & audit 01

*/мян.төг/*

## 17. УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР

| | 2024.12.31 | 2023.12.31 |
|---|---|---|
| Урт хугацаат өр төлбөр | 2,945,393 | 36,466,251 |
| Бонд | 29,028,833 | 16,593,258 |

## 18. НӨӨЦ /БОЛЗОШГҮЙ ӨР ТӨЛБӨР

| | 2024.12.31 | 2023.12.31 |
|---|---|---|
| Нөөц | 113,351 | - |

## 19. ХУВЬЦААТ КАПИТАЛ

Компани нь Монгол Улсын Компанийн тухай хуулийн дагуу үүсгэн байгуулагдс хязгаарлагдмал хариуцлагатай компани. Нийт зөвшөөрөгдсөн бөгөөд гаргасан энги хувьцааны тоо ширхэг нь 800,000,000 бөгөөд нэгж хувьцааны нэрлэсэн үнэ 10 төгр Гаргасан бүх хувьцаа нь бүрэн төлөгдсөн. Нэгж энгийн хувьцаа нь 1 саналын эрхтэй. Компанийн шууд толгой компани нь Анд Системс бөгөөд эцсийн толгой компани Сингапур улсад бүртгэлтэй, финтек гарааны компани болох Анд Глобал ПтиЛтд. Хувьцаа эзэмшигчид болон тэдгээрийн эзэмшлийн хувийг доорх хүснэгтэд харуулав

| | 2024.12.31 | 2023.12.31 |
|---|---|---|
| Анд Системс | 75.0% | 75.0% |
| Олон нийт | 17.4% | 17.4% |
| Халаасны хувьцаа | 7.6% | 7.6% |
| | 100.0% | 100.0% |

## 20. ХАЛААСНЫ ХУВЬЦАА

| | 2024.12.31 | 2023.12.31 |
|---|---|---|
| Халаасны хувьцаа | 2,337,547 | 2,337,547 |

SHONKHOR 01 estimate & audit

*/мян.төг/*

## 21. ХҮҮГИЙН ОРЛОГО, ЗАРДАЛ

| | 2024.12.31 | 2023.12.31 |
|---|---|---|
| **Хүүгийн орлого** | **88,801,668** | **47,982,386** |
| Хугацаандаа байгаа зээлийн хүүгийн орлого | 78,332,141 | 37,288,690 |
| Хугацаа хэтэрсэн зээлийн хүүгийн орлого | 686,947 | 366,826 |
| Үйлчилгээний хураамжийн шимтгэлийн орлого | 9,789,039 | 10,339,988 |
| (Хүүгийн орлогын буцаалт) | (6,459) | (13,118) |
| **Харилцах хадгаламжийн хүүгийн орлого** | **388,368** | **29,685** |
| Харилцах дансны хүүгийн орлого | 41,677 | 2,070 |
| Банкин дахь хадгаламжийн хүүгийн орлого | 346,691 | 24,184 |
| Үнэт цаасны хүүгийн орлого | - | 3,431 |

## 22. ХҮҮГИЙН БОЛОН ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ЗАРДАЛ

| | 2024.12.31 | 2023.12.31 |
|---|---|---|
| Банкны байгууллагаас авсан зээлийн хүүгийн зардал | 2,848,725 | 447,300 |
| Бусад санхүүгийн байгууллагаас авсан зээлийн хүүгийн зардал | 5,075,203 | 1,614,312 |
| Өрийн бичгийн хүүгийн зардал | 4,732,671 | 4,218,707 |
| Итгэлцлийн үйлчилгээний зардал | 9,195,705 | 4,611,377 |
| Түрээсийн хөрөнгийн хүүгийн зардал | 329,240 | 93,097 |
| | **22,181,544** | **10,984,792** |
| Хүүгийн зардал ТЗК | - | (1,457,448) |
| | **22,181,544** | **9,527,344** |

*/мян.төг/*

## 23. УДИРДЛАГА БОЛОН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ

| | 2024.12.31 | 2023.12.31 |
|---|---|---|
| Цалин хөлсний зардал | 4,005,298 | 2,858,334 |
| Ажилтнуудад олгосон тэтгэмж, нийгмийн халамж | 38,703 | 35,336 |
| Нийгмийн даатгал ЭМД шимтгэл | 498,478 | 352,507 |
| Бичиг хэргийн зардал | 33,701 | 38,810 |
| Сургалтын зардал | 42,365 | 10,574 |
| Авлага барагдуулахтай холбогдон гарсан зардал | 112,652 | 20,121 |
| Аудитын төлбөр, мэргэжлийн үйлчилгээний зардал | 1,245,110 | 1,303,131 |
| Даатгал | 51,671 | 39,490 |
| Түрээс | 15,951 | 1,080 |
| Ашиглалтын зардал | 14,271 | 11,692 |
| Элэгдлийн зардал | 876,467 | 615,968 |
| Харилцаа холбоо, интернэт | 562,152 | 497,538 |
| Шатахуун, тээврийн зардал | 15,378 | 13,789 |
| Сэлбэг хэрэгсэл, засвар үйлчилгээ | 139,913 | 25,644 |
| Зохицуулалт үйлчилгээний хөлс | 9,906 | 14,271 |
| Автоматжуулалттай холбоотой | 263 | 419 |
| Зар сурталчилгаа, маркетингийн зардал | 425,855 | 482,737 |
| Техник үйлчилгээний зардал | 2,123,539 | 2,222,570 |
| Лицензийн зардал | 428,394 | 473,391 |
| Серверийн үйлчилгээний зардал | 455,496 | 456,183 |
| Хэтэвч үйлчилгээний төлбөр | 207,689 | 241,504 |
| Кью пэй үйлчилгээний зардал | 216,519 | 171,754 |
| Лавлагааны зардал | 248,095 | 179,196 |
| Шимтгэлийн зардал | 175,377 | 138,061 |
| Бусад зардал | 542,947 | 142,500 |
| | **12,486,190** | **10,223,652** |

## 24. ХҮҮГИЙН БУС ОРЛОГО

| | 2024.12.31 | 2023.12.31 |
|---|---|---|
| Мөнгөн гуйвуулгын орлого | 27,397 | |
| Тэнцлийн гадуурх тооцооны төлөлт | 209,741 | 146,299 |
| Бусад орлого | 34,518 | 2,840 |
| **Хүүгийн бус орлого** | **271,656** | **149,139** |

SHONKHOR 01 estimate & audit

*/мян.төг/*

## 25. ҮНДСЭН БУС ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ

| | 2024.12.31 | 2023.12.31 |
|---|---|---|
| Зочин төлөөлөгчийн зардал | 103,888 | 64,615 |
| Баяр ёслол | 190,417 | 208,289 |
| Бусад зардал | 24,871 | 134,019 |
| **Үндсэн бус үйл ажиллагааны зардал** | **319,176** | **406,923** |

## 26. ОРЛОГЫН ТАТВАРЫН ЗАРДАЛ, ТООЦОО

Тайлант жилийн орлого, үр дүнгийн тайланд тусгагдсан орлогын албан татварын зардлыг дор үзүүлэв:

| | 2024.12.31 | 2023.12.31 |
|---|---|---|
| Тайлант жилийн орлогын албан татварын зардал | 10,131,219 | 5,574,907 |
| Тайлант жилийн хойшлогдсон татварын зардал | (117,608) | |
| | **10,013,611** | **5,574,907** |

| *Жилийн орлогын албан татварын өр төлбөрийн хөдөлгөөн:* | 2024.12.31 | 2023.12.31 |
|---|---|---|
| 2024 оны 01-р сарын 01 | 3,807,327 | 901,876 |
| Тухайн жилийн орлогын албан татварын зардал | 10,013,611 | 5,574,907 |
| Орлогын албан татвар төлсөн | 10,254,533 | 2,669,456 |
| 2024 оны 12 сарын 31 | 3,566,405 | 3,807,327 |

Компани орлогын албан татварын зардлыг санхүүгийн тайлангийн татварын өмнөх ашгийг орлогын татвар ногдохгүй орлого болон татвар ногдуулах орлогоос хасагдахгүй зардлаар тохируулга хийх замаар тооцон бүртгэдэг. Компани нь Монгол Улсын татварын хууль тогтоомжийн дагуу 6 тэрбум хүртэлх төгрөгийн албан татвар ногдуулах жилийн орлого олсон бол 10 хувиар, 6 тэрбум төгрөгөөс дээш давсан орлогын дүнгийн 25 хувиар орлогын албан татвар төлдөг.

SHONKHOR 01 estimate & audit

*/мян.төг/*

## 27. НЭГЖ ХУВЬЦААНД НОГДОХ АШИГ

Компанид шингэрүүлэх боломжтой энгийн хувьцаа байхгүй учир нэгж хувьцаанд ногдох үндсэн болон шингэрүүлсэн ашгийн дүн тэнцүү болно.

| | 2024 | 2023 |
|---|---|---|
| Тайлант жилийн цэвэр ашиг буюу хувьцаа эзэмшигчдэд ногдох нийт дэлгэрэнгүй орлого (мян.төг) | 36,113,649 | 19,795,816 |
| Нэгж хувьцаанд ногдох үндсэн болон шингэрүүлсэн ашгийг тооцоолоход ашиглах энгийн хувьцааны жигнэсэн дундаж тоо* | 739,301,683 | 739,301,683 |

| | 2024 | 2023 |
|---|---|---|
| **Нэгж хувьцаанд ногдох ашиг** | | |
| Хувьцаа эзэмшигчдэд: | | |
| Нэгж хувьцаанд ногдох үндсэн болон шингэрүүлсэн ашиг (төг) | 48.85 | 26.78 |

SHONKHOR 01
estimate & audit